



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН**  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА






## БҮТЭЦ, ОРОН ТОО

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газар болон Газрын тосны газрыг нэгтгэн Ашигт малтмал, газрын тосны газар болгон орон тооны дээд хязгаарыг 185 байхаар баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Үндэсний геологийн алба байгуулагдсантай холбогдуулан тус газраас 35 орон тоог Үндэсний геологийн албанд шилжүүлж, Ашигт малтмал, газрын тосны газрын орон тооны дээд хязгаарыг 150 байхаар шийдвэрлэсэн.

Ашигт малтмал, газрын тосны газар нь дарга, салбар хариуцсан 2 орлогч дарга, 11 хэлтэс нэгжтэй, төрийн захиргааны 120, төрийн үйлчилгээний 30 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.





## ЭРХЭМ ЗОРИЛГО

Ашигт малтмал, газрын тосны газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга, тэгш хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

### Хууль эрх зүйн орчин

Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээрийг дагалдан гарсан журам, Засгийн газраас батлагдсан бодлогын баримт бичгүүд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын бодлогын удирдамжийг хэрэгжүүлэн ажилладаг.



## ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Тус газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт УИХ, ЗГ, УУХҮЯ-аас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахаас гадна холбогдох хууль, журмын биелэлтийг хангах зорилтуудын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Геологи хайгуулын салбарын чиглэлээр: Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хатуу, шингэн, хийн төлөвт ашигт малтмалын геологи хайгуулын судалгааг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх зорилтын хүрээнд ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эрэл болон хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянан хүлээн авах, хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд хүлээн авч, бүртгэх;

2. Уул уурхайн салбарын чиглэлээр: тус салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд уулын ажлын төлөвлөгөө, тайланг хянан хүлээн авах, уулын болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хянах, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, салбарын ААН-үүдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэгтгэж, түүнд тулгуурласан судалгаа, санал, дүгнэлт боловсруулах;



## ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


3. Газрын тосны салбарын чиглэлээр: Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд тус салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөцийг өсгөх, ордыг ашиглалтад шилжүүлэх, тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой хангах, газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц бүрдүүлэх, үнийн судалгаа явуулах, дотоодын жижиглэнгийн үнийг тогтвортой байлгахад хяналт тавих;

4. Хүнд үйлдвэрийн чиглэлээр салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновацийн идэвхжилтийн судалгааг хийх чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.





# УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

## 2020 оны 10 сарын байдлаарх статистик үзүүлэлт




ДОТООДЫН  
НИЙТ  
БҮТЭЭГДЭХҮҮН

АЖ  
ҮЙЛДВЭРИЙН  
НИЙТ  
ҮЙЛДВЭРЛЭЛ



ГАДААДЫН  
ШУУД  
ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТ

ЭКСПОРТ



**НҮҮРС**  
2.8 их наяд  
төг  
16.2 сая тн



**ЗЭС**  
3.3 их наяд төг  
Баяж. 1021 м.тн  
Кат.зэс 6 тн



**АЛТ**  
2.1 их наяд ₮  
17.1 тн



**ТӨМРИЙН  
ХҮДЭР**  
1.3 их наяд төг  
6.25 сая.тн




**ЦАЙРЫН  
БАЯЖМАЛ**  
347.3  
тэрбум.төг  
103 мян.тн



**ЖОНШ**  
322.8 тэрбум төг  
460.6 мян.тн

АЖИЛЛАГСАД



Алт – 2020 оны 09 дүгээр сарын Монгол банкны тушаалтын мэдээ  
ДНБ - Үндэсний статистикийн хороо  
Аж - Үндэсний статистикийн хороо  
Гадаадын шууд хөрөнгө оруулалт – Монгол банк  
Экспорт – Гаалийн ерөнхий газар



## 2016-2020 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

### 1. АМГТГ-аас Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого.

Нийт 2016-2020 онд **1.1** их наяд төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна (2020.09.30-ны байдлаар). Үүнээс:

- Газрын тосны экспортын орлого **848.9** тэрбум төгрөг буюу нийт орлогын 76.2%,
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр **173.4** тэрбум төгрөг буюу нийт орлогын 15.6%,
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр **21.7** тэрбум төгрөг буюу нийт орлогын 1.9%,
- Бусад орлого **23.6** тэрбум төгрөг буюу нийт орлогын 2.1%,
- Өөрийн орлого буюу Сонгон шалгаруулалтын орлого **57.7** тэрбум төгрөг буюу нийт орлогын 4.2%-ийг тус тус эзэлж байна.






## 2016-2020 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

### 2. Газрын тосны бүтээгдэхүүний үнийг бууруулав.

- Сүүлийн 10 жилийн туршид тогтмол өсөж байсан газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг 2019 оноос хойш таван удаагийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгээр литр тутамд нь 380-570 төгрөгөөр тус тус бууруулж ажилласан.
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 14 дүгээр тогтоол, 3 дугаар сарын 27-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор тус тус өгсөн үүрэг, чиглэлийн дагуу өргөн хэрэглээний суурь бүтээгдэхүүн болох Аи-92 автобензиний үнийг тогтворжуулах зорилгоор “Эрчис Ойл” ТӨХХК болон газрын тосны бүтээгдэхүүн импортлогч 15 аж ахуйн нэгжүүдийн хооронд 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан “**Аи-92 төрлийн автобензиний жижиглэнгийн үнийг тогтворжуулах**” гэрээнд хяналт тавьж ажилласан.
- Үүний үр дүнд Монгол улсын шатахууны нийт жижиглэнгийн худалдааны 60 орчим хувийг эзэлдэг АИ-92 автобензиний үнэ 1400-1450 төгрөгт тогтвортой хадгалагдаж байгаа бөгөөд энэ нь өргөн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхгүй байхад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.







## 2016-2020 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

### 3. Цахим мэдээллийн санг бий болгов.

Монгол улсын хэмжээнд хийгдсэн геологийн судалгааны ажлуудын товч мэдээллийг монгол, англи хэл дээр онлайнаар авч болох “МонГеоКат” төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлсэн. Тус цахим мэдээллийн сангаас Геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа 9300 орчим тайлангуудтай сүлжээнд холбогдсон иргэн бүр танилцаж, хэрэгцээт мэдээллээ авах бүрэн боломжтой болсон. Уг программаар “**Дэлхийн орон зайн мэдээллийн форум**”-д оролцож 2018 оны шилдэг программ хангамжаар шалгарсан болно.

### 4. Ашигт малтмалын нөөцийн улсын балансыг зохиов.

Олон жилээр хийгдээгүй хоцрогдолтой байсан ашигт малтмалын нөөцийн улсын балансыг ашигт малтмалын 31 төрлөөр хууль журмын дагуу гаргаж холбогдох дээд байгууллага болох УУХҮЯ болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт нөхөн тайлагнасан. Үүнд:

- Металл ашигт малтмалын нөөцийн балансыг 2010 оноос эхлэн 7 жилээр
- Алтны шороон ордуудын нөөцийн балансыг 2010 оноос эхлэн 9 жилээр
- Металл бус ашигт малтмалын нөөцийн балансыг 1990 оноос 27 жилээр
- Хайлуур жоншны нөөцийн балансыг 2006 оноос эхлэн 10 жилээр тус тус гаргасан

### 5. Геологи, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайланг хүлээн авах цахим системийг бий болгов.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх үйлчилгээг түргэн, шуурхай, ил тод болгох, орон зайн хамааралгүйгээр харилцах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2016 оноос хойш геологи, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахим системээр хүлээн авч эхэлсэн бөгөөд 2020 оноос цахим системийн 2-р ээлжийн хөгжүүлэлтийг эхлүүлээд байна.

### 6. Стратегийн ордуудын хил заагийг тогтоолгов.

УУХҮЯ-тай хамтран Стратегийн ордын хил заагийг тогтоох саналыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Засгийн газрын 2017 оны 109, 2018 оны 300 тоот тогтоолоор тус тус стратегийн ач холбогдол бүхий **8 ордын** талбайн хил заагийг тогтоосноор УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлсэн.



## 2016-2020 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

### 7. ОХУ-аас хуучин тайлангуудыг хүлээн авав .

ОХУ-ын “Росгео” фондод хадгалагдаж байсан Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд 1950-1990 онуудад гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын 70 ширхэг тайланг 2018 онд хүлээн авч нийтийн хэрэгцээнд гаргасан.

### 8. Гурван талт хэлцэл байгуулав.

Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор 2018 оны 10 дугаар сард АМГТГ, Дорнод аймгийн Засаг дарга, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-тай гурван талт хэлцэл байгуулж, аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-д жил бүр 500 мянган ам. доллар төвлөрүүлэх, мөн 2020 оны 2 дугаар сард Халх гол, Матад сумдтай гурван талт гэрээ байгуулж, тус бүрт жилд 450 мянган ам. доллар сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-д төвлөрүүлэх ажлыг тус тус зохион байгуулав.

### 9. Талбайг чөлөөлж төрийн мэдэлд буцаан авав.

2016 оны байдлаар ашигт малтмалын нийт 3580 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байснаас өнөөдрийн байдлаар нийт 2645 тусгай зөвшөөрөл болж буурсан бөгөөд 2016-2020 онуудад Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчин үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжийн 935 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг тухай бүрт нь цуцлан холбогдох шийдвэрийг гаргаж нийт 185,651.58 гектар талбайг чөлөөлж төрийн мэдэлд буцаан авав.

### 10. Төрийн өмчит ААН-үүдэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгов.

2019 онд төрийн өмчийн “Эрдэнэс Монгол” компанид Багануур нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл, төрийн өмчийн “Эрдэнэс силвер ресурс” компанид Салхитын мөнгөний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл, Засгийн газрын 2020 оны 212 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн “Эрдэнэс алт ресурс” компанид хайгуулын 4 тусгай зөвшөөрөл, “Эрдэнэс силвер ресурс” компанид хайгуулын 2 тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.



## 2016-2020 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

### 11. Сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг ил тод, нээлттэй болгов.

УИХ-аас 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр АМТХ-д өөрчлөлт оруулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зөвхөн **сонгон шалгаруулалтын журмаар** олгохоор хуульчилсан. Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 243 дугаар тогтоолоор Сонгон шалгаруулалтын журмаар олгох боломжтой 8.4 сая гектар талбайн солбицлыг тогтоож нийтэд зарласан. **Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/38, А/62 дугаар тушаалаар** 2019 оны 1 дүгээр улирлаас хойш сонгон шалгаруулалтын 1 болон 2 дугаар комиссын бүрэлдэхүүнийг батласан. Уг **комисст** олон нийтийн төлөөллийг оруулж хяналтыг сайжруулснаар хайгуулын тусгай зөвшөөрлийн олголтын үйл ажиллагаа **олон нийтэд ил тод** болсон.

### 12. Хүнд үйлдвэрийн мэдээллийн сан бий болгов.

2020 онд “Arcgis” форматын “Web” хувилбарт үндэслэсэн хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нэгтгэн боловсруулалт хийж Монгол улсын хэмжээний хүнд үйлдвэрүүдийн мэдээллийн санг бий болгов.

### 13. Газрын тос, уламжлалт бус газрын тосны шинэ орд нээх боломж бүрдэв.

- “Петроматад” ХХК-ийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ/БХГ/-т “Матад ХХ” талбайд 2019 онд 3 цооног өрөмдсөнөөс 2 цооног газрын тос илэрсэн бөгөөд өнөөдрийн байдлаар тухайн ордын **нөөцийг** тооцоолж баталгаажуулахаар ажиллаж байна.
- “Эрдэнэс метан” ХХК Тавантолгой ХХХIII талбайд эрлийн ажил гүйцэтгэж **10** тэрбум метр.куб нүүрсний давхаргын метан хийн баялгийг тооцоолоод байна.
- “Тэлмэн Ресурс” ХХК Өмнөговь аймгийн Гурвантэс орчимд эрлийн ажил гүйцэтгэж **298** тэрбум метр.куб нүүрсний давхаргын метан хийн баялгийг тооцоолоод байна.

### 14. ССОР-ийн гишүүн болов.

2018 онд “Зүүн болон Зүүн өмнөд Азийн геологийн шинжлэх ухааны хүрээлэн”/ССОР/-гийн орон тооны гишүүнээр элсэн орж, 2019 онд гишүүн 16 орны төлөөлөгч оролцсон “Уламжлалт бус газрын тос-14” олон улсын хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.



## 2016-2020 ОНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

### 15. Олон жил шинэчлэгдээгүй байсан салбарын эрх зүйн актуудыг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж шинэчлэн батлуулав.

- Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”
- Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах зарцуулах журам”
- Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”
- Засгийн газрын 2017 оны 151 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах журам”
- Засгийн газрын 2020 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн түүхий эдийн жагсаалт”
- Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм
- Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм
- Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
- Ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулга



## ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРИЙН ХУВААРИЛАЛТ

Газрын тосны нөөц ашигласны төлбөр			
Он	Нөөц ашигласны төлбөр /тэрбум.төг/	Улсын төсөвт (70%)	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд (30%)
2018	33.5	23.4	10.0
2019	35.9	25.2	10.8
2020.09	10.4	7.3	3.1
Нийт	79.9	55.9	24.0


Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр				
Он	Тусгай зөвшөөрлийн төлбөр /тэрбум.төг/	Улсын төсөвт (70%)	Аймаг, нийслэлийн төсөвт (20%)	Сум, дүүргийн төсөвт (10%)
2018	1.9	1.4	0.4	0.2
2019	2.2	1.5	0.4	0.2
2020.09	0.9	0.7	0.2	0.1
Нийт	5.1	3.6	1.0	0.5

Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын дагуу Улсын төсөвт төвлөрүүлсэн төлбөрүүдийг хуваарилах тооцоог 2018 оноос хойш улсын төсөв, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөв тус бүрээр хийж, дүн мэдээг сар бүр Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнээс:

- 2018-2020 онд (2020.09-р сарын байдлаар) Нөөц ашигласны төлбөрт нийт **79.9** тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт **55.9** тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд **24.0** тэрбум төгрөг хуваарилсан,
- Тусгай зөвшөөрлийн төлбөрт нийт **5.1** тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт **3.6** тэрбум төгрөг, аймгуудын төсөвт нийт **1.0** тэрбум төгрөг, сумуудын төсөвт нийт **0.5** тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.




# ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, ТОГТООГДСОН НӨӨЦ, АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА






## ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТ, ОРЛОГО





## ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛ



Монгол улсын хэмжээнд 1998 оноос хойш 8,7 сая тонн газрын тос экспортолж, улсын төсөвт 960,5 сая ам.доллар буюу 1,7 ихнаяд төгрөгийг төвлөрүүлээд байна.

БХГ-т талбай	Нийт ӨНЗ (тэрбум \$)	Өртөгт тосоор нөхөгдсөн (тэрбум \$)	Ирээдүйд нөхөгдөх (тэрбум \$)	Өртөг нөхөлтийн хувь	
				Нөхөгдсөн	Ирээдүйд нөхөгдөх
Тосон-Уул XIX	2.25	(0.9)	1.34	40.2%	59.8%
Тамсаг XXI	1.31	(0.4)	0.91	30.4%	69.6%
БХГ-97	0.30	(0.15)	0.15	51.4%	48.6%
<b>Нийт (1993-2019)</b>	<b>3.85</b>	<b>(1.45)</b>	<b>2.40</b>	<b>37.7%</b>	<b>62.3%</b>

- Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд 1993-2019 онд нийт **4.15** тэрбум ам.долларын өртөг нөхөгдөх зардал гарсан байна.
  - ✓ Үүнээс 2016-2019 онд нийт **905.7** сая ам.доллар
  - ✓ Нийт **4.15** тэрбум ам.долларын өртөг нөхөгдөх зардлын **93%** буюу **3.85** тэрбум ам.доллар нь ашиглалтын талбайд, **7%** буюу **297.2** сая ам.доллар нь хайгуулын талбайд ногдож байна.
- Газрын тосны ашиглалтын 3 талбайн өртөг нөхөлтийн дундаж хувь 2019 оны жилийн эцсийн байдлаар **37.7** хувьтай байна.







# АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ

Монгол улсын хэмжээнд геологийн судалгааны ажлаар бүрхэгдсэн байдал

Хувийн хөрөнгөөр гүйцэтгэж буй ашигт малтмалын хайгуулын ажлын тайлан төлөвлөгөөг хүлээн авах, ашигт малтмалын нөөц бүхий тайланд үнэлэлт өгөх, шаардлагатай тохиолдолд газар дээр нь шалган баталгаажуулах, хайгуулын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэн ажилладаг.




Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй геологийн судалгааны ажил /тэрбум.төг/




Д/Д	Төрөл	2017	2018	2019	2020
1	1:50000-ны масштабтай геологийн судалгааны ажил	13	6	4	4
2	1:200000-ны масштабтай геологийн судалгааны ажил	1	1		
3	Сэдэвчилсэн судалгааны ажил	2	3	2	1
4	Геофизикийн судалгааны ажил		2		

Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан, баталгаажуулалт, шуурхай хяналт



Хайгуулын ажлын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл /тэрбум төгрөг/



2016-2020 онд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн эрэл, хайгуулын ажлын нөхөн төлбөрийн гэрээгээр 18.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.


# ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ

Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ:  
Газрын тосны 5, шатдаг занар, нүүрсний давхаргын метан хий зэрэг уламжлалт бус газрын тосны 13, **НИЙТ 18** гэрээ хэрэгжиж байна.

Эрлийн гэрээний үр дүнд 2020 онд:  
ЗГ-н 57 дугаар тогтоолоор **3** талбайд, 143 дугаар тогтоолоор **1** талбайд, уламжлалт газрын тосны **1**, нийт **5** БХГ байгуулсан.

“Эрдэнэс метан”ХХК Тавантолгой ХХХIII талбайд эрлийн ажил гүйцэтгэж **10** тэрбум метр.куб нүүрсний давхаргын метан хийн баялгийг тооцоолоод байна.

“Тэлмэн Ресурс”ХХК Өмнөговь аймгийн Гурвантэс орчимд эрлийн ажил гүйцэтгэж **298** тэрбум метр.куб нүүрсний давхаргын метан хийн баялгийг тооцоолоод байна.




# ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ

Газрын тосны хайгуулын 17 талбай, Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 5 талбайд үйл ажиллагаа явагдаж байна.

“Петроматад” ХХК-ийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ/БХГ/-т “Матад ХХ” талбайд 2019 онд 3 цооног өрөмдсөнөөс 2 цооногт газрын тос илэрсэн бөгөөд өнөөдрийн байдлаар тухайн ордын нөөцийг тооцоолж баталгаажуулахаар ажиллаж байна.

“Жи Өү Эйч” ХХК Номгон IX талбайд 237,2 тууш км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа, 4821,8 тууш.метр 8 цооног өрөмдөж нүүрсний давхаргын метан хийн сонирхол татахуйц үр дүн илэрч хайгуулын ажил амжилттай үргэлжилж ОУ хөрөнгийн бирж дээр хувьцааны үнэ өсөлттэй байна.








## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар  
Гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээлэлд тулгуурлав.




2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар  
Монголбанкны алт тушаалтын мэдээнд тулгуурлав.






## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ




■ Гянтболдын баяжмал, тн




■ Цагаантулганы баяжмал, тн

2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар  
Гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээлэлд тулгуурлав.



■ Катодын зэс, (мян.тн)




■ Молибдены баяжмал, мян.тн

■ Төмрийн хүдэр, баяжмал, сая.тн



## УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН ИРҮҮЛСЭН БАЙДАЛ (%-иар)





# УУЛ УУРХАЙ, ГАЗРЫН ТОСНЫ ТӨВ ЛАБОРАТОРИ

## Үйл ажиллагааны чиглэл

- Экспортын нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний чанарын төвшинг тодорхойлох
- Уул уурхайн орчны хөрс, усны бохирдлыг тодорхойлох шинжилгээ, туршилт гүйцэтгэх,
- Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох.
- Шатах ашигт малтмалын химийн найрлага, бүтэц, физик, механик, дулааны шинж чанарыг тодорхойлох шинжилгээг гүйцэтгэх

### Хатуу түлш, нүүрсний лаборатори



Ахлах шинжээч-1  
Шинжээч-2  
Дээж бэлтгэгч-1  
47 багаж

### Газрын тосны бүтээгдэхүүний лаборатори



Ахлах шинжээч-1  
Шинжээч-2  
50 багаж

### Хөрс, усны лаборатори




Хөрс, усны шинжилгээ:  
Шинжээч-1  
93 багаж

УУГТТЛ нь нийт 190 нэр төрлийн шинжилгээний багаж тоног төхөөрөмжтэй.



## Улсын төсөвт оруулсан орлого, сая ₮





## КАДАСТРЫН СТАТИСТИК МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын бүртгэлд 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр **2645** ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй. Үүнд:

Тусгай зөвшөөрлийн төрөл	Тоо	Талбайн хэмжээ гектар	Нийт нутгийн эзлэх %
Хайгуул	952	4,611,135.43	3.0%
Ашиглалт	1693	1,624,392.32	1.0%
<b>Нийт</b>	<b>2645</b>	<b>6,235,527.75</b>	<b>4.0%</b>

2016 оны байдлаар ашигт малтмалын нийт 3580 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байснаас 2020 онд нийт 2645 тусгай зөвшөөрөл болж буурсан бөгөөд 2016-2020 онуудад Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчин үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжийн 935 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг тухай бүр нь цуцлан холбогдох шийдвэрийг гаргаж нийт 185,651.58 гектар талбайг чөлөөлж төрийн мэдэлд буцаан авсан.





## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ОЛГОЛТ /2016-2020 он/

№	Бүртгэлийн төрөл	2016	2017	2018	2019	2020.10.19	НИЙТ
1	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	93	77	61	59	52	342
2	Өргөдлөөр олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл /шүүхийн шийдвэрийн дагуу/	625	23	5		2	655
	Нөхөх олговроор дүйцүүлэн олгосон /ЗГ-ын 2017 оны 256 тогтоолоор /		18				18
	ЗГ-ын 2015 оны 359-р, 2020 оны 212 дугаар тогтоолоор тус тус олгогдсон	4				6	10
3	Сонгон шалгаруулалтаар олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл	28	26	19	71	6	150
	Сонгон шалгаруулалтаар олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл /хязгаарлагдмал/		7				7
4	<b>Нийт</b>	<b>750</b>	<b>151</b>	<b>85</b>	<b>130</b>	<b>66</b>	<b>1182</b>

УИХ-аас 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр АМТХ-д өөрчлөлт оруулан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зөвхөн **сонгон шалгаруулалтын журмаар** олгохоор хуульчилсан. Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 243 дугаар тогтоолоор Сонгон шалгаруулалтын журмаар олгох боломжтой 8.4 сая гектар талбайн солбицлыг тогтоож нийтэд зарласан.

**Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/38, А/62 дугаар тушаалаар** 2019 оны 1 дүгээр улирлаас хойш сонгон шалгаруулалтын 1 болон 2 дугаар комиссын бүрэлдэхүүнийг батласан. Уг **комисст** олон нийтийн төлөөллийг оруулж хяналтыг сайжруулснаар хайгуулын тусгай зөвшөөрлийн олголтын үйл ажиллагаа **олон нийтэд ил тод** болсон.

### Сонгон шалгаруулалтын орлогоор улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүн /2016-2020 он/

№	Орлогын төрөл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Сонгон шалгаруулалтын орлогын /АМГТГ/	6,9 тэрбум төгрөг	16,1 тэрбум төгрөг	13,2 тэрбум төгрөг	19,4 тэрбум төгрөг	2,1 тэрбум төгрөг
<b>Нийт дүн</b>		<b>57,7 тэрбум төгрөг</b>				




## ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ САНАЛ

№	Орон нутаг болон бусад талуудын оролцоотой харилцаанд үүсч буй хүндрэлүүд	
1	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа	- Газрын тосны боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, хайгуулын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр гарсан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч ажиллахыг орон нутгийн удирдлагад Засгийн Газрын зүгээс тусгайлан чиглэл өгүүлэх саналтай байна.
2	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа	- Хуулийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийн байгууллагын зүгээс хууль бус үндэслэл, шаардлага тавих замаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд саад учруулах явдал түгээмэл байгаа тул тухайн хууль бус асуудлыг хуулийн дагуу зохицуулах арга хэмжээ авч ажиллаагүй аймгийн Засаг даргад Засгийн Газрын зүгээс хариуцлага тооцдог болгох саналтай байна.
3	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа	- Орон нутаг мэргэжлийн боловсон хүчний нөөц бололцоо муутай, ажлын дадлага туршлагагүй байдлаас хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг хангалттай хэрэгжүүлж чадахгүй байгаа нь хайгуулын ажил хийлгүйгээр нөөц батлуулах, өөр төрлийн ашигт малтмал хайх, олборлох гэж оролдох, тусгай зөвшөөрлийн төлбөр төлөлт давхардах, орхигдох, нөөц, ТЭЗҮ батлуулалгүйгээр олборлолтын үйл ажиллагааг дур мэдэн эхлүүлэх зэрэг зөрчлүүд түгээмэл тохиолдож байна. -Мөн Геологи, уул уурхайн кадастрын болон улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэл алдагдаж, нөөцийн хөдөлгөөн хийгдэхгүй байгаа нь салбарын эрдэс баялгийн нөөцийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо, цогц бодлого баримтлах боломжгүй болгож байгаа тул тухайн хуулийг хүчингүй болгох саналтай байна.



# ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ САНАЛ

№	Эрх зүйн орчныг боловсронгуй болгох
4	<p>Газрын тосны тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актууд</p> <ul style="list-style-type: none"><li>-Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%-ийг тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн санд шууд шилжүүлэх.</li><li>-Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрөл өгөөгүйн улмаас хайгуулын ажил зогссон. /Смарт ойл Монголиа ХХК-ийн Эргэл XII талбайд хийгдэх 2019 оны ажил зогссон/</li><li>-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 заалтыг хэрэгжүүлэхэд нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэлийг авах нь хүндрэлтэй байдаг.</li><li>-Хилийн 15 км-т болон тусгай хамгаалалттай талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулахыг хориглосон асуудал судалгаа хийх боломжийг хязгаарлаж байна. Жишээ нь: Макс Ойл ХХК-ийн Арбулаг ХХИХ талбайтай залгаа БНХАУ-ын талд Монгол улсын хилийн шугамаас 300-500 м зайд 2012 оноос хойш олборлолтын үйл ажиллагаа явагдаж байна.</li></ul>
5	<p>Ашигт малтмалын тухай хууль</p> <ul style="list-style-type: none"><li>- Уулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлэх болон албажуулах хугацааг тодорхой болгох,</li><li>- Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөрийн зохицуулалтыг нарийвчлах,</li><li>- Нөөц дууссан, үйл ажиллагааны болон технологийн зөрчил гаргасан ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлах эрх зүйн орчинг бүрдүүлэх,</li><li>- Геологи, уул уурхайн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, нэмэгдүүлэх зорилгын хүрээнд өргөдлийн журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хууль эрхзүйн зохицуулалтыг бий болгох,</li><li>- Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох</li></ul>



# ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ САНАЛ

№	Эрх зүйн орчныг боловсронгуй болгох	
6	Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах	<p>- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр-ийн 3.2-т Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шудрага хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ. гэж заасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд эрдэс баялгийн салбарын 10 хуульд дүн шинжилгээ хийж, хийт 267 давхардал, 150 зөрчил, 150 хийдэл тогтоосон байна. Дээр дурдсан судалгааны хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.24 дэх хэсэгт заасны дагуу УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах шаардлагатай байна.</p>
7	Шатахууны жижиглэнгийн үнэ тогтворжуулах талаар	<p>- 2020 онд Засгийн газрын 114 дүгээр тогтоолын дагуу хэрэгжүүлж буй шатахууны жижиглэнгийн үнэ тогтворжуулах механизмыг амжилттай хэрэгжүүлснээр Аи-92 автобензины үнэ 1450 төг/л тогтвортой байгаагийн адил 2021 онд бусад төрлийн (Аи-95 автобензин, дизелийн түлш) шатахуунд хэрэгжүүлэх боломжийг шийдвэрлүүлэх саналтай байна.</p>



# АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР



## *Анхаарал хандуулсанд баярлалаа*



Хаяг: Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр, Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар 15170, Монгол Улс

Утас: +976-51-263953

Факс: +976-51-263953

Веб хаяг: [www.mrpm.gov.mn](http://www.mrpm.gov.mn)

